БАТЛАВ
САЙНШАНД ХОТЫН ЗАХИРАГЧ
Ч.ТҮВШИНТӨР

2026 оны 01 дүгээр сарын 13 өдөр

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2026 оны 01 дүгээр сарын 13 Сайншанд хот

Сайншанд сумын өвс тэжээлийн агуулахын зориулалттай газрын гадна цахилгаан хангамжийн ажил

А. Ажил гүйцэтгэх хугацааны график хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоог тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Барилгын норм ба дүрэм /БНбД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх.

В. Үнийн саналд захиалагчийн хяналтын зардлыг талбайн угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 2%-иар, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тооцож тусгаж ирүүлнэ.

Г. Төсөв зохиохдоо Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 30 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНбД "IY" 81-95-12-г мөрдлөг болгоно.

Д. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.

Е. Тендерт зураг төсвийн үнэ **8 330 000** төгрөг тусгаж ирүүлэх.

Суурь болон газар шорооны ажил

Байгалийн хөрсийг гараар нүдэн баримжаагаар тэгшлэн хайрган дэвсгэр үе хийн 1,5тн хүртэл жинтэй гулдмай угсрах, газардуулга, кабелийн шуудуу, тулгуурын нүхийг механизмаар болон гараар ухаж, булах.

250кВА чадалтай КТПН угсрах ажил

10кВ-ын 250ква хүртэл чадалтай иж бүрэн дэд өртөө гадаа байрлуулж угсрах, 10кВ-ын 1тн хүртэл жинтэй хүчний хувьсгуур ба реакторт үзлэг шалгалт хийх, халаалт хийх, 160мм2 хүртэл огтлолтой газардуулгын шинийг шуудуунд угсрах, газардуулгын гадас зоож хүрээнд гагнах Ф22.

10кВ-ын кабель шугамын ажил

6-10кВ-ын 3х70мм2 кабелийг шуудуунд сунгах, тулгуурт сунгах, станцад сунгах, элсэн дэвсгэр, тоосгон хучилт эхний кабельд хийх, 6-10 кВ-ын 3 судастай 70мм2 хүртэл огтлолтой кабельд лент хэрэглэж хуурай үзүүрлэгээ хийх, 10кВ-ын 3 судастай 70мм2 хүртэл огтлолтой кабельд төгсгөлийн муфт тавих, 70мм2 хүртэл огтлолтой кабелийн судсанд төгсгөвч шахах, сувагчлалын болон газрын кабельд хамгаалалтын тууз дэвсэх.

10кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил

10кВ-ын шонгийн нүхнүүдийн цэгийг тэмдэглэж гадас зоох, П10-9Б маркийн төмөр бетон засврын тулгуур угсарч босгох, АК10-4Б маркийн төмөр бетон төгсгөлийн анкер тулгуур угсарч босгох, УА10-5Б маркийн төмөр бетон 45 градус хүртэл эргэлтийн анкер тулгуур угсарч босгох, ОА10-4Б маркийн төмөр бетон салбарлалтын тулгуур угсарч босгох, 6, 10кВ-ын ЦДАШ-ын тулгуурт тулаас хийж нэмэлт траверс суурилуулах, 6-10кВ-ын хүчдэлтэй агаарын шугамын 50мм2 огтлолтой СИП утасыг зөрлөггүйг татах, 6-10кВ-ын агаарын шугамын хуурай салгуурыг тулгуур угсрах, 6-10кВ-ын хүчдэлтэй шугамд гэмтэл заагч угсрах, гараар цэнэг шавхагчийг угсрах, зөөврийн газардуулгын хавчаар угсрах, утаснуудыг хавчааараар холбож залгаас хийх, завсарын шугам, анкер шугамын тулгуурт газардуулгын буулт хийх, газардуулгын шинийг сунгаж шуудунд тавих, газардуулгын гадас зоож шинтэй холбож гагнах, шугамын арматур, төмөр бетон шон ба хөндлөвч, хөндийрүүлэгч, дамартай утас, троссыг агаарын шугамын трассын дагуу ачиж буулгах. Газардуулгын ажлыг хийж гүйцэтгэхдээ БД 43-101-03*12 газардуулга ба цахилгааны аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг мөрдөж ажиллана. Тус ажлыг хийж гүйцэтгэхдээ эрчим хүчний сайдын 2014 оны 101 дүгээр тушаалаар батлагдсан "Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг мөрдлөг болгон ажиллах.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. ЦДАШ-ын угсралтын ажлыг батлагдсан төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНбД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Ажлын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
4. Гүйцэтгэсэн ажил тус бүрд ил, далд ажлын акт бичиж, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
5. ЦДАШ-ын угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
6. Ажлын зураг төсөлд зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт оруулах болвол захиалагч болон зураг төслийн байгууллагатай зөвшилцөнө. Зөвшөөрөлгүйгээр газар дээр өөрчлөхийг хориглоно.
7. Гүйцэтгэгч нь ажлын явцыг фото зураг, ил далд ажлын актаар баталгаажуулж, талбайн журналыг өдөр тутам хөтлөнө. Улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий

байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.

8. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу ЦДАШ-ын угсралтын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

9. Монгол улсын "Барилгын тухай" хуулийн 14.3-т /барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна/ 14.4-т /14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ/ 14.5-д /14.4-т заасны дагуу зөрчлийг арилгаснаар 14.3-т заасан хугацаа дуусгавар болсонд тооцно/ 14.6-д /14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа 3-аас доошгүй жил байна/ гэж заасныг үндэслэн гүйцэтгэгч байгууллага чанарын баталгаа гаргаж өгнө. Хуулиар тогтоосон чанарын баталгаат хугацаанд байгалийн болон давтагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад шалтгаанаас үүдэн барилга байгууламжид аливаа доголдол, эвдрэл, гэмтэл гарвал гүйцэтгэгч компани нь Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.9.2-д заасны дагуу үнэ төлбөргүй, үл маргах журмаар засварлаж, ашиглалтын хэвийн байдалд оруулах үүрэг хүлээнэ.

ХЯНАСАН:

САЙНШАНД ХОТЫН ЗАА-НЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЭНХЧИМЭГ

3310302. 0621070007. ЭТО044

БОЛОВСРУУЛСАН:

САЙНШАНД ХОТЫН ЗАА-НЫ
ГЦХХХМЭРГЭЖИЛТЭН Г.НАРАН-ЭНХЗУЛ